



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 326

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.2, 6.2.3, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 455,346.40 (дөрвөн зуун тавин таван мянга гурван зуун дөчин зургаан төгрөг дөчин мөнгө) төгрөгийн балансын үнэ, 70,053.36 (далан мянга тавин гурван төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.
2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:
 - 2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, үлдэгдэл өртгөөр нь хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
 - 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
 - 2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.
3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Үндсэн хөрөнгө акталж, данснаас

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 07
дугаар сарын 08-ний өдрийн
316 дугаар тогтоолын хавсралт

**Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж
данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1	Гадна төмөр хашаа	455,346.40	70,053.36	385,293.04
		455,346.40		385,293.04
	ХӨРӨНГИЙН ДҮН	455,346.40 (дөрвөн зуун тавин таван мянга гурван зуун дөчин зургаан төгрөг дөчин мөнгө)	70,053.36 (далан мянга тавин гурван төгрөг гурчин зургаан мөнгө)	385,293.04 (гурван зуун наян таван мянга хоёр зуун ерэн гурван төгрөг дөрвөн мөнгө)